



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/297

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 42 дугаар зүйлийн 42.2.1.в дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр суманд баригдах дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам сүлжээний ажлын зураг, төсөл боловсруулах ажлын үлдэгдэл санхүүжилтэд 63,076,374 (жаран гурван сая далан зургаан мянга гурван зуун далан дөрөв) төгрөгийг зарцуулсугай.

2. “Ричвэлл инженеринг” ХХК-тай тооцоо хийж дээрх 63,076,374 (жаран гурван сая далан зургаан мянга гурван зуун далан дөрөв) төгрөгийн зардлыг техник хяналт, барьцаа хөрөнгийн данснаас шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100634